



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/87/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.18 № 05
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН СТАНДАРТ
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
С.ЧУЛУУНБАТ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал:

1. Тус байгууллагын аж ахуйн бараа материалын дансанд архивын гар скайнер 311.0 мянга, архивын шат 100.0 мянга, стикер самбар 1,210.0 мянган төгрөг нийт 1,821.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 4.4-д "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө" заалт, УСНББОУСтандартын 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн дансанд хийн Соната-7 маркийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй. Гэтэл үндсэн данснаас 4,672.8 мянган төгрөгийг Петровис ХХК-ийн шатахууны картаар дамжуулан зарцуулахдаа А-92, дизель түлш авч зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нярав, нягтлан бодогч нар үнэн бодитоор хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,897,904.16</u>	<u>10,441,214.16</u>
33	АВЛАГА	6,311,123.16	3,612,305.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	950,800.00	-
335	Бусад авлага	5,360,323.16	3,612,305.16
3351	Байгууллагаас авах авлага	5,360,323.16	3,612,305.16
35	БАРАА МАТЕРИАЛ	6,586,781.00	6,828,909.00
351	Түүхий эд материал	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	264,000.00
354	Хангамжийн материал	6,586,781.00	6,564,909.00
35410	Бичиг хэргийн материал	1,342,429.00	1,825,759.00
35420	Аж ахуйн материал	5,244,352.00	4,739,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,980,338.55</u>	<u>83,933,158.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,980,338.55	83,933,158.16
392	Биет хөрөнгө	61,980,338.55	83,658,158.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,385,668.18)	(16,385,668.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,210,730.05	209,698,678.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(120,064,606.95)	(142,259,403.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,814,116.49	33,168,347.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,594,232.86)	(20,563,796.19)
393	Биет бус хөрөнгө	-	275,000.00
39301	Програм хангамж	722,500.00	997,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(722,500.00)	(722,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>74,878,242.71</u>	<u>94,374,372.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>92,209.35</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	92,209.35	-
413	Өглөг	92,209.35	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	92,209.35	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>74,786,033.36</u>	<u>94,374,372.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	74,786,033.36	94,374,372.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,179,695.00	41,179,695.00
51101	Өмч: - төрийн	41,179,695.00	41,179,695.00
512	Хуримтлагдсан үр дүн	31,871,398.83	51,459,737.79
51210	Өмнөх үеийн үр дүн	31,871,398.83	31,871,398.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,588,338.96
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,734,939.53	1,734,939.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>74,878,242.71</u>	<u>94,374,372.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	272,837,921.15	361,817,003.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,162,021.15	118,830,403.20
120	Нийтлэг татварын бус орлого	76,162,021.15	118,830,403.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,162,021.15	114,396,530.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,162,021.15	114,396,530.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		3,457,333.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ		976,540.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,675,900.00	242,986,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	195,725,100.00	239,326,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195,725,100.00	239,326,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	950,800.00	3,660,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	950,800.00	3,660,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	293,464,341.04	342,228,664.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,464,341.04	342,228,664.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,618,634.89	284,760,235.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,916,900.00	160,388,098.18
210101	Үндсэн цалин	100,239,200.00	129,205,225.94
210102	Нэмэгдэл	30,812,800.00	19,142,831.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,864,900.00	5,229,100.00
210104	Урамшуулал	-	6,810,941.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,633,517.00	21,540,905.88
210201	Тэтгэврийн даатгал	11,338,567.63	14,877,502.55
210202	Тэтгэмжийн даатгал	1,358,038.79	1,599,330.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,086,430.63	1,265,836.60
210204	Ажилгүйдлийн даатгал	282,812.76	238,562.62
210205	Эрүүл мэндийн даатгал	2,567,667.19	3,559,674.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,519,586.00	27,422,461.14
210301	Гэрэл, цахилгаан	507,724.00	611,432.00
210302	Түлш, халаалт	3,790,000.00	3,769,770.08
210303	Цэвэр, бохир ус	572,657.00	876,779.06
210304	Байрны түрээс	16,649,205.00	22,164,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,156,773.00	11,663,192.00
210401	Бичиг хэрэг	1,909,564.00	2,914,665.00
210402	Тээвэр, шатахуун	3,673,000.00	4,856,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	1,237,555.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,500.00	63,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	562,420.00	1,340,589.00
210408	Бараа материал акталсны зардал	948,289.00	1,250,093.00
2105	Нормативт зардал	-	3,794,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,795,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	999,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	5,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	800,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,243,000.00	7,654,000.00
210702	Дотоод албан томилолт	6,243,000.00	7,654,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	992,080.00	1,951,780.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	676,780.00

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,800.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	149,000.00	710,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,156,778.89	45,144,848.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	5,924,554.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,347,872.00	2,136,982.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,208,906.89	37,083,312.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,845,706.15	57,468,428.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,078,500.00	53,105,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,355,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,078,500.00	750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,591,021.15	4,363,328.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,591,021.15	4,363,328.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,626,419.89)	19,588,338.96
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,626,419.89)	19,588,338.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	268,266,921.15	362,904,930.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,591,021.15	118,967,530.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,591,021.15	118,967,530.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,591,021.15	118,967,530.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,591,021.15	118,967,530.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,675,900.00	243,937,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	195,725,100.00	239,326,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195,725,100.00	239,326,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	950,800.00	4,610,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	950,800.00	4,610,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	267,266,921.15	308,466,130.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,266,921.15	308,466,130.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,098,915.00	250,997,701.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,916,900.00	160,388,099.18
210101	Үндсэн цалин	100,239,200.00	107,692,444.94
210102	Нэмэгдэл	30,812,800.00	47,466,554.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,864,900.00	5,229,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,989,600.00	21,633,114.23
210201	Тэтгэврийн даатгал	11,552,900.00	15,236,899.08
210202	Тэтгэмжийн даатгал	1,359,200.00	1,603,899.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,087,400.00	1,283,099.42
210204	Ажилгүйдлийн даатгал	271,800.00	337,089.62
210205	Эрүүл мэндийн даатгал	2,718,300.00	3,172,127.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,467,205.00	30,245,443.14
210301	Гэрэл, цахилгаан	801,400.00	880,756.00
210302	Түлш, халаалт	3,790,000.00	4,718,771.08
210303	Цэвэр, бохир ус	803,000.00	646,436.06
210304	Байрны түрээс	16,072,805.00	23,999,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,149,130.00	9,473,815.00
210401	Бичиг хэрэг	1,999,930.00	1,999,960.00
210402	Тээвэр, шатахуун	3,673,000.00	4,672,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	1,237,555.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,500.00	63,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	412,700.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	-	3,794,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,795,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	999,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,140,000.00	5,970,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,000.00	170,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	800,000.00

210604	Урсгал засвар	2,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,243,000.00	7,654,000.00
210702	Дотоод албан томилолт	6,243,000.00	7,654,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	992,080.00	2,438,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	676,780.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,800.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	149,000.00	1,197,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,201,000.00	9,399,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	6,399,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,601,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,168,006.15	57,468,428.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,450,000.00	53,105,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,355,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,591,021.15	4,363,328.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,591,021.15	4,363,328.45
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	950,800.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	950,800.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	176,185.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,185.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,000,000.00</u>	<u>54,438,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,000,000.00</u>	<u>54,438,800.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1,000,000.00</u>	<u>54,438,800.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,000,000.00	54,438,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.00	54,438,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,000,000.00)</u>	<u>(54,438,800.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
14	Бусад эх үүсвэр	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	52,497,818.72	95,412,453.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	52,497,818.72	95,412,453.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,626,419.89)	(20,626,419.89)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	31,871,398.83	74,786,033.36
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	31,871,398.83	74,786,033.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	31,871,398.83	74,786,033.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	19,588,338.96	19,588,338.96
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.00	1,734,939.53	51,459,737.79	94,374,372.32

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7-р зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга С.Чулуунбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 28-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Орхон аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандарт, хэмжил зүйн, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогыг үйл ажиллагаагаар дэмжихэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Өмнөх онуудад 100% улсын төсвөөс санхүүждэг байсан бол 2020 оноос эхлэн тодорхой хувийг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр өөрчлөлт орсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй 2016 онд боловсруулсан бөгөөд шинэчлэгдэн гарсан стандарт, хууль, журмыг тусгаагүй байна.

Стандарт хэмжил зүйн газраас 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлого 223,526.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,235.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 361,817.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,618.2 мянган төгрөг болгон өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,496.2 мянган төгрөгөөр буюу 26 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	6,311.10	3,612.30	-2,698.80
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	6,586.80	6,828.90	242.10
Үндсэн хөрөнгө	61,980.30	83,933.20	21,952.90
Нийт хөрөнгө	74,878.20	94,374.40	19,496.20
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	41,179.70	41,179.70	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	74,878.20	94,374.40	19,496.20

Авлага дансны үлдэгдэл 3,612.3 мянган төгрөг болж 2,698.8 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага 950.8 мянга, бусад зардлын тооцооны авлага 4,571.0 мянга, гэрэл цахилгаан 293.7 мянга, цэвэр бохир ус 230.3 мянган төгрөгөөр буурч, тайлант онд гэрэл цахилгаан 563.0 мянга, түлш халаалт 949.0 мянга, түрээс 1,835.0 мянга нийт 3,347.0 мянган төгрөгийн авлага нэмж бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2004-2005 онуудад үүссэн, он удаан жил болсон 265.3 мянган төгрөгийн Сэргээн босголт банкны авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 265.3 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь насжилт ихтэй тул найдваргүй авлага болох эрсдэл өндөр байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 83,933.2 мянган төгрөг болж 21,952.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд машин тоног төхөөрөмж 51,983.8 мянга, тавилга эд хогшил 6,777.3 мянга, программ хангамж 275.0 мянга нийт 59,036.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, элэгдлээ бүрэн нөхсөн 18,918.9 мянга төгрөгийн хөрөнгө акталж, тайлант оны хуримтлагдсан элэгдэл 37,083.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 55,578.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,457.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 275.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нярвын программ худалдан авснаас шалтгаалжээ.

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайланд өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 41,179.7 мянган төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 88,979.1 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 43,601.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих нь 38,234.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь засгийн газрын шийдвэрээр цалингийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 48,764.3 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, тэтгэмжийн зардлууд байна. Энэ нь тайлант онд цалинг засгийн газрын шийдвэрээр нэмсэн болон хоёр ажилтан тэтгэвэрт гарч тэтгэмж олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 429,126.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 429,126.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74,799.8 мянган төгрөгөөр бууруулж 354,326.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд эд хогшил худалдан авах зардлыг 120,129.0 мянган байхаар тусгасан боловч 64,329.0 мянган төгрөгөөр хасаж 55,800.0 мянган төгрөгөөр баталсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 354,326.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 239,326.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 115,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 239,326.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 114,396.5 мянган төгрөг, өмнөх оны авлага 4,571.0 мянган төгрөг тайлант онд орж, нийт 358,294.1 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 353,930.8 мянган төгрөгийг зарцуулж 4,363.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 358,294.1 мянган төгрөг буюу 101.1 хувьтай байгаа нь нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 2,321.4 мянган төгрөгөөр, хэтрүүлж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг илүү зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 2,321.4 мянган төгрөгөөр илүү зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,660.0 мянга, татаас санхүүжилтийн өмнөх авлага 950.8 мянга нийт 4,610.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тавилга эд хогшилд 2,625.0 мянга, багаж техник хэрэгсэлд 1,985.8 мянга, нийт 4,610.8 мянган төгрөгийг зарцуулсан.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.10-р зүйлд заасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлгийг хийж мэдээлээгүй. Мөн байгууллагын даргын тушаалаар төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбогдон гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Хуулийн 6.4.5 заалтын дагуу 5,000.0 мянган төгрөгөөс дээш дүн бүхийн орлого зарлагын гүйлгээг буруу, дутуу мэдээлсэн байхад аудитын явцад залруулга хийлгэж нөхөж мэдээлүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилт бүртгэгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 253,751.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 234,624.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,493.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 3,347.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шатахууны урамшуулал 183.9 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй байсны залруулж бүртгүүлсэн.
2. Үр дүнгийн урамшуулал 6,810.9 мянган төгрөгийг нэмэгдэл цалинд тайлагнасан.
3. Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 1,139.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
4. Авлага 10.9 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан.
5. Няравын программ 275.0 мянган төгрөгөөр худалдан авсныг шууд зарлагадсан байсныг бүртгэлд тусгуулсан.
6. Үндсэн хөрөнгийн бүртгэлд 864.9 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу бүртгэлд тусгасныг тус тус залруулж бүртгүүлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 9,840.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,493.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тус байгууллагын аж ахуйн бараа материалын дансанд архивын гар скайнер 311.0 мянга, архивын шат 100.0 мянга, стикер самбар 1,210.0 мянган төгрөг нийт 1,821.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 4.4-д “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө” заалт, УСНББОУСтандартын 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд хийн Соната-7 маркийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй. Гэтэл үндсэн данснаас 4,672.8 мянган төгрөгийг Петровис ХХК-ийн шатахууны картаар дамжуулан зарцуулахдаа А-92, дизель түлш авч зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нярав, нягтлан бодогч нар үнэн бодитоор хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3,347.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, шатахуун зарцуулалтын анхан шатны баримтын бүрдлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. Тус бодлогын баримт бичиг нь 4 жилийн өмнө батлагдсан тул шинэчлэгдэн гарсан стандарт хууль, дүрэм журмыг тусган шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн бүртгэл стандартын дагуу бүртгэгдэхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021.02.19 30 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийг хэт өндөр төлөвлөж батлуулснаас оны эцэст үүссэн хэмнэлтийг дараа оны зардалд шилжүүлэн авлага үүсгэсэн байна. Тухайлбал: Гэрэл цахилгаан 563.0 мянга, түлш халаалт 949.0 мянга, түрээс 1,835.0 мянган төгрөг нийт 3,347.0 мянган төгрөгийн авлагыг нэмж бүртгэсэн.

2.2. Эрсдэл: Харилцагч байгууллага өглөгөөр хүлээн зөвшөөрүүлж бүртгээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021.02.19 30 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Аудитор

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор



Т.БОЛОРМАА

Б.ЭРДЭНЭ

Ц.НАРМАНДАХ

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

		Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	
			ОРА-2021/87/СТА-ТШЗ

Огноо:

Аудитын код:

2021	Аудитын нэр: Шалгарсан байгууллагын нэр:	Алдаа, зөрчлийн төрөл, үзэг Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс	Мөнгөн дүн Мянган төгрөг	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	
				Нэр	Албан тушаал Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллагын аж ахуйн бараа материалын дансанд архивын гар скайнер 311.0 мянга, архивын шат 100.0 мянга, стикер самбар 1,210.0 мянган төгрөг нийт 1,821.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэн.	1,821.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Чулуунбат, Ц.Булганчимэг
2	Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд хийн Соната-7 маркийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй. Гэтэл үндсэн данснаас 4,672.8 мянган төгрөгийг Петровис ХХК-ийн шатахууны картаар дамжуулан зарцуулахдаа А-92, дизель түлш авч зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нярав, нягтлан бодогч нар үнэн бодитоор хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан	4,672.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Чулуунбат, Ц.Булганчимэг
3	Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. Тус бодлогын баримт бичиг нь 4 жилийн өмнө батлагдсан тул шинэчлэгдэн гарсан стандарт хууль, дүрэм журмыг тусган шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.		Зөвлөмж хүргүүлэв.	Дарга, нягтлан бодогч	С.Чулуунбат, Ц.Булганчимэг
4	Тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийг хэт өндөр төлөвлөж батлуулснаас оны эцэст үүссэн хэмнэлтийг дараа оны зардалд шилжүүлэн авлага үүсгэсэн байна. Тухайлбал: Гэрэл цахилгаан 563.0 мянга, түлш халаалт 949.0 мянга, түрээс 1,835.0 мянган төгрөг нийт 3,347.0 мянган төгрөгийн авлагыг нэмж бүртгэсэн.	3,347.0	Зөвлөмж хүргүүлэв.	Дарга, нягтлан бодогч	С.Чулуунбат, Ц.Булганчимэг
ДҮН		9,840.8			

Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Аудитор

Т.БОЛОРМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 03/02 ОАА-2021/87/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд хийн Соната-7 маркийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй. Гэтэл үндсэн данснаас 4,672.8 мянган төгрөгийг Петровис ХХК-ийн шатахууны картаар дамжуулан зарцуулахдаа А-92, дизель түлш авч зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нярав, нягтлан бодогч нар үнэн бодитоор хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Тээвэр шатахуунд 4,672.8 мянган төгрөгийг зарцуулахдаа хийн Соната-7 авто машинд А-92 бензин, дизель түлш авч зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийгээгүй, нярав, нягтлан бодогч нар үнэн бодитоор хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад

бүртгэлээр тавих хяналт алдагдсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн газрын дарга С.Чулуунбат, нягтлан бодогч Ц.Булганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 04/04 ОА-2021/87/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын аж ахуйн бараа материалын дансанд архивын гар скайнер 311.0 мянга, архивын шат 100.0 мянга, стикер самбар 1,210.0 мянган төгрөг нийт 1,821.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэн.

Мөн аж ахуйн материалын дансанд бусад бараа материалыг нэр төрөл, зориулалтаар ангилан ялгаагүй, хольж бүртгэсэн нь бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 4.4-д "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө", УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 1,821.0 мянган төгрөг, аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй байгаа материалыг нэр төрөл зориулалтаар нь ангилан 2021 оны эхний хагас жилийн тайланд залруулан бүртгэж, цаашид бараа материалаар бүртгэхгүй байх, зөрчлийг бүрэн арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн газрын дарга С.Чулуунбат, нягтлан бодогч Ц.Булганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР Т.БОЛОРМАА

